



**БОЛОВСРОЛ,
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

БАРИМТ БИЧИГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинэчилсэн огноо: 2017.03.20

2016 он

АГУУЛГА

1. Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр бакалаврын сургалтад суралцахаар өргөдөл гаргагчийн баримт бичгийн шаардлага.....6
2. Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр магистрантур, докторантурт суралцахаар өргөдөл гаргагчийн баримт бичгийн шаардлага.....9
3. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадад суралцахаар өргөдөл гаргагчийн баримт бичгийн шаардлага3

1. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадад суралцахаар өргөдөл гаргагчийн баримт бичгийн шаардлага

Цахим өргөдөл бөглөж илгээх болон түүнд хавсаргах баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна.

Ерөнхий шаардлага:

- 1. Баримт бичиг тус бүрийг 1 PDF файл болгон тухайн баримт бичгийн монгол нэрээр нэрлэсэн байх;**
Жишээлбэл: Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, сургуулийн урилга, ерөнхий боловсролын сургуулийн гэрчилгээ, дүнгийн тодорхойлолт, ... гэх мэт
- 2. Нэг төрлийн баримт бичгийг 1 л удаа хавсаргаж оруулах;**
Хэрэв олон хуудастай баримт бичиг бол 1 PDF файл болгон урьдчилж бэлтгэсний дараа тухайн төрлийн баримт бичгийг системд нэг л удаа татаж оруулна. Нэг төрлийн баримт бичгийг дахин татаж оруулах үед системээс хавсаргах боломжгүй тухай анхааруулга өгнө.
- 3. PDF файл болгосон баримт бичгийн хуудасны хэмжээ A4 болон түүнээс доош хэмжээтэй байх;**
Хэрэв таны хавсаргасан PDF файлын доторх хуудас бүрийн хэмжээ A4-өөс дээш хэмжээтэй бол таны баримт бичгийг хэвлэж гаргах боломжгүй болохыг анхаарна уу. Тиймээс PDF файл болгосон баримт бичгийнхээ файлыг нээж, хуудас бүрийн хэмжээг шалгаж үзсэний дараа A4 болон түүнээс доош хэмжээтэй бол хавсаргаж болно.
- 4. Баримт бичгийн төрлийг зөв сонгох;**
Баримт бичгийг оруулахдаа баримт бичгийн төрлийг зөв сонгож, шаардсан баримт бичгийн бүх төрлийг бүрэн татаж оруулна. Хавсаргах ёстой баримт бичгийг системээс “Баримт бичгийн төрөл”-өөр нь шалгах бөгөөд төрөл дутуу тохиолдолд системээс өргөдөл илгээгдэхгүй тухай анхааруулга өгнө.
- 5. Хавсаргах 1 файлын дээд хэмжээ 5MB байх;**
- 6. PDF файл нь нууцлалтай (secured) файл биш байх;**
Хэрэв PDF файл нь нууцлалтай (secured) файл бол хавсаргах үед системээс хавсаргах боломжгүй тухай анхааруулга өгнө. Нууцлалгүй файлыг хавсаргах боломжтой байна.
- 7. Баримт бичгийн хуулбар цэвэрхэн, үг үсэг бүр уншигдахуйц байх;**
8. Сургуулийн урилга болон ерөнхий боловсролын гэрчилгээ бусад боловсролын баримт бичиг англи эсвэл монгол хэл дээр биш бол тэдгээрийн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг монгол хэл дээрх албан ёсны нотариатаар баталгаажуулсан орчуулгын хамт 1 PDF файл болгон хавсаргах;
9. Биечлэн ярилцлагад орох иргэн бүрдүүлсэн баримт бичгийн эх хувийг ярилцлагад орохдоо заавал авч ирэх;

Өргөдөлд баримт бичиг хавсаргах шаардлага:

Дараах баримт бичгийн жагсаалтаас өөрийн өргөдөл гаргах тэтгэлэгт шаардлагатай баримт бичгийг хавсаргана.

Санамж: Доорх хэсэгт байж болох нийт баримт бичигт тавигдах шаардлагыг дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд тэтгэлэгт хүсэлт гаргагч нь зөвхөн зарлалд дурдсан шаардлагатай баримт бичгийг цахим өргөдөлд хавсаргахыг анхаарна уу.

1. Цахим өргөдөл бөглөж, илгээх;
Хэрэглэгчийн эрх үүсгэн системд нэвтэрч, цахим өргөдөл бөглөж илгээнэ. Ингэхдээ бүх мэдээллийг үнэн зөв бөглөж, дараах бичиг баримтуудыг заасан шаардлагын дагуу өргөдөлд хавсаргана.
2. Суралцаж буй сургуулийн тодорхойлолтыг хавсаргах;
Сургуулийн албан бланк дээр, сургуулийн захирлын гарын үсэг, тамгатай, тухайн цаг үеийн огноотой байна.
3. Дүнгийн хуулбар хавсаргах;
Суралцаж буй сургуулийн холбогдох албан тушаалтны гарын үсэг, тамгатай хамгийн сүүлийн улирлын дүнг хавсаргана.
4. Хэлний бэлтгэл анги төгссөн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар эсвэл бэлтгэл ангийн дүнгийн тодорхойлолт хавсаргах;
Хэлний бэлтгэл төгссөн гэрчилгээ эсвэл дүнгийн жагсаалтын нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргана.
5. Бүрэн дунд боловсролын гэрчилгээ болон дүнгийн хуулбарын нотариатаар баталгаажуулсан хуулбарыг нэг PDF болгон хавсаргах;
6. Иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргах;
Иргэний үнэмлэхний 2 талын нүүрийг оруулан нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргана.
7. Сонгон шалгаруулалтын бүртгэлийн хураамж 15 000 төгрөгийг төлсөн баримтын хуулбарыг хавсаргах;
Бүртгэлийн хураамжийг Төрийн сан дахь БСШУСЯамны 100900015431 (дансны нэр: БСШУСЯам н.с) тоот дансад тушаана. Хураамж төлсөн баримтад бүртгүүлэгчийн овог, нэр, регистрийн дугаар, утасны дугаар, гүйлгээний утга буюу ямар тэтгэлэгт, ямар түвшинд суралцахаар бүртгүүлэх тухай (Жишээ 1: ОХУ-Роснефть, бакалавр; Жишээ 2: Польш, магистр; Жишээ 3: БНХАУ-ын ЗГ тэтгэлэг, доктор; Жишээ 4: БНХАУ Тусгай тэтгэлэг, магистр гэх мэт) мэдээллийг заавал оруулах шаардлагатай.
БСШУСЯам н.с
Дансны дугаар 100900015431
8. Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт хавсаргах;
Зөвхөн докторантурт суралцах өргөдөлд гаргагчид эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт хавсаргана. Сурталчилгааны чанартай бүтээл хамаарахгүй.
9. Суралцах чадварыг харуулсан тодорхойлолт хавсаргах;
Суралцах бэлтгэл, судалгаа, шинжилгээний ажлын туршлага, зан төлөвийн онцлогийг тодорхойлсон удирдагч, багш, эрдэмтний тодорхойлолтыг хавсаргана.
10. Ажил, зан байдлын тодорхойлолт хавсаргах;

Ажиллаж байгаа эсвэл ажиллаж байсан газраас олгосон ажил, зан байдлыг харуулсан тодорхойлолтыг хавсаргана.

11. Бакалавр /магистрантурт өргөдөл гаргах бол/, бакалавр болон магистр /докторантурт өргөдөл гаргах бол/-ийн диплом, дүнгийн жагсаалтын нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргах;
Магистрт өргөдөл гаргах бол бакалаврын диплом болон дүнгийн жагсаалтын нотариатаар баталгаажуулсан хуулбар, докторт өргөдөл гаргах бол бакалавр болон магистрын диплом тэдгээрийн дүнгийн жагсаалтын нотариатаар баталгаажуулсан хуулбарыг тус тус хавсаргана.
12. Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргах;
Нийгмийн даатгалын дэвтрийн сүүлийн 5 жил хүртэлх мэдээллийг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. Үүнд: нийгмийн даатгалын дэвтрийн нүүр хуудас, сүүлийн 5 жил хүртэлх хугацааны төлөлт хийгдсэн тухай мэдээлэл, албан тушаалд томилсон, чөлөөлсөн тухай тэмдэглэлийг харуулсан хуудас зэргийг заавал оруулна.
13. Гадаад хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт өгсөн тухай баримтын хуулбарыг хавсаргах;
Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад хэдний шалгалт /IELTS, TOEFL гэх мэт/ өгсөн гэрчилгээний хуулбар эсвэл суралцах сургуулийн гадаад хэлний шаардлагыг хангаж байгааг нотлох аливаа баримтын хуулбарыг хавсаргана.
14. Судалгааны ажлын тухай товч реферат хавсаргах;
2000-аас илүүгүй үгэнд багтаан судалгаа хийж буй чиглэл, ашигласан арга зүй, хүрсэн гол үр дүн, дүгнэлтээ илэрхийлсэн байна.

Жич: Та цахим өргөдлийг бөглөж илгээсэн эсэхээс үл хамааран бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй тул сонгон шалгаруулалтад тавигдах шаардлагыг сайтар судалсны дараа төлбөрийг дансанд тушаана уу.

2. Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр бакалаврын сургалтад суралцахаар өргөдөл гаргагчийн баримт бичгийн шаардлага

Цахим өргөдөл бөглөж илгээх болон түүнд хавсаргах баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна.

Ерөнхий шаардлага:

- 1. Баримт бичиг тус бүрийг 1 PDF файл болгон тухайн баримт бичгийн монгол нэрээр нэрлэсэн байх;**
Жишээлбэл: Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, сургуулийн урилга, ерөнхий боловсролын сургуулийн гэрчилгээ, дүнгийн тодорхойлолт, ... гэх мэт
- 2. Нэг төрлийн баримт бичгийг 1 л удаа хавсаргаж оруулах;**
Хэрэв олон хуудастай баримт бичиг бол 1 PDF файл болгон урьдчилж бэлтгэсний дараа тухайн төрлийн баримт бичгийг системд нэг л удаа татаж оруулна. Нэг төрлийн баримт бичгийг дахин татаж оруулах үед системээс хавсаргах боломжгүй тухай анхааруулга өгнө.
- 3. PDF файл болгосон баримт бичгийн хуудасны хэмжээ А4 болон түүнээс доош хэмжээтэй байх;**
Хэрэв таны хавсаргасан PDF файлын доторх хуудас бүрийн хэмжээ А4-өөс дээш хэмжээтэй бол таны баримт бичгийг хэвлэж гаргах боломжгүй болохыг анхаарна уу. Тиймээс PDF файл болгосон баримт бичгийнхээ файлыг нээж, хуудас бүрийн хэмжээг шалгаж үзсэний дараа А4 болон түүнээс доош хэмжээтэй бол хавсаргаж болно.
- 4. Баримт бичгийн төрлийг зөв сонгох;**
Баримт бичгийг оруулахдаа баримт бичгийн төрлийг зөв сонгож, шаардсан баримт бичгийн бүх төрлийг бүрэн татаж оруулна. Хавсаргах ёстой баримт бичгийг системээс “Баримт бичгийн төрөл”-өөр нь шалгах бөгөөд төрөл дутуу тохиолдолд системээс өргөдөл илгээгдэхгүй тухай анхааруулга өгнө.
- 5. Хавсаргах 1 файлын дээд хэмжээ 5MB байх;**
- 6. PDF файл нь нууцлалтай (secured) файл биш байх;**
Хэрэв PDF файл нь нууцлалтай (secured) файл бол хавсаргах үед системээс хавсаргах боломжгүй тухай анхааруулга өгнө. Нууцлалгүй файлыг хавсаргах боломжтой байна.
- 7. Баримт бичгийн хуулбар цэвэрхэн, үг үсэг бүр уншигдахуйц байх;**
8. Сургуулийн урилга болон ерөнхий боловсролын гэрчилгээ бусад боловсролын баримт бичиг англи эсвэл монгол хэл дээр биш бол тэдгээрийн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг монгол хэл дээрх албан ёсны нотариатаар баталгаажуулсан орчуулгын хамт 1 PDF файл болгон хавсаргах;
9. Биечлэн ярилцлагад орох иргэн бүрдүүлсэн баримт бичгийн эх хувийг ярилцлагад орохдоо заавал авч ирэх;

Өргөдлийн шаардлага:

Дараах баримт бичгийн жагсаалтаас өөрийн өргөдөл гаргах тэтгэлэгт шаардлагатай баримт бичгийг хавсаргана.

Санамж: Доорх хэсэгт байж болох нийт баримт бичигт тавигдах шаардлагыг дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд тэтгэлэгт хүсэлт гаргагч нь зөвхөн зарлалд дурдсан шаардлагатай баримт бичгийг цахим өргөдөлд хавсаргахыг анхаарна уу.

1. Цахим өргөдөл бөглөж, илгээх;
Хэрэглэгчийн эрх үүсгэн системд нэвтэрч, цахим өргөдөл бөглөж илгээнэ. Ингэхдээ бүх мэдээллийг үнэн зөв бөглөж, дараах баримт, бичгүүдийг заасан шаардлагын дагуу цахим өргөдөлд файл хэлбэрээр хавсаргана.
2. Сургуулийн албан захидал/урилгын хуулбарыг хавсаргах;
Суралцах урилга авсан бол: Жагсаалтад багтсан сургуулийн бакалаврын үндсэн, өдрийн ангийн сургалтад /хэлний бэлтгэл хамаарахгүй/ зарлагдсан мэргэжлийн чиглэлийн дагуу 2016 онд шууд суралцахаар элсүүлсэн тухай сургуулийн албан захидлын хуулбарыг хавсаргана. Хэрэв та нэгээс дээш их сургуульд суралцах урилга авсан бол суралцахаар сонгож буй сургуулийн мэдээллийг цахим өргөдлийн тэтгэлэг авах үндсэн сургалтын хөтөлбөр хэсэгт оруулж бусад тэнцсэн сургуулийн мэдээллийг тэтгэлэг авах бусад сургалтын хөтөлбөр хэсэгт оруулж болох бөгөөд сургуулиудын урилгыг баримт бичиг хэсэгт 1 PDF файл болгон хавсаргана. Суралцах сургуулийн урилга англи хэлнээс өөр хэл дээр бол монгол хэл дээрх албан ёсны орчуулгыг хамт нэг файл болгон хавсаргах;
Суралцаж байгаа бол: Жагсаалтад багтсан сургуулийн бакалаврын үндсэн, өдрийн ангийн сургалтад суралцаж байгаа тухай сургуулийн албан бичиг хавсаргана. Суралцах сургуулийн албан захидал, дүнгийн хуулбар англи хэл дээр биш бол монгол хэл дээрх албан ёсны орчуулгыг хамт нэг файл болгон хавсаргана.
3. Суралцах зорилго болон мэргэжил, сургуулиа сонгосон байдал, суралцах тухай болон төгсөөд хийх ажлын төсөөлөл зэргийг илэрхийлсэн эссэ хавсаргах;
Эссэ тус бүр А4*2 нүүрнээс хэтрэхгүй, times new roman 12 бичигдсэн байх, монгол ба тухайн суралцах орны хэл дээр бичнэ. Жишээлбэл: Англи хэл дээр суралцах бол монгол болон англи хэл дээр бичнэ.
4. Суралцах сургуулийн гадаад хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт өгсөн тухай баримтын хуулбарыг хавсаргах;
Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад хэлний шалгалт /IELTS, TOEFL гэх мэт/ өгсөн бол гэрчилгээний хуулбарыг хавсаргах эсвэл суралцах сургуулийн гадаад хэлний шаардлагыг хангаж байгааг нотлох аливаа баримт бичгийн хуулбарыг хавсаргана.
5. Төрсний гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар хавсаргах;
6. Иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар хавсаргах;
Иргэний үнэмлэхний 2 талын нүүрийг оруулан нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргана.
7. Боловсролын баримт бичиг болон дүнгийн хавсралтын нотариатаар баталгаажуулсан хуулбар хавсаргах;

Бүрэн дунд боловсролын үнэмлэх авсан бол үнэмлэх болон дүнгийн хавсралтын нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргана.

Бүрэн дунд боловсролын үнэмлэх аваагүй, ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй бол суралцаж буй сургуулийн сүүлийн 2 улирлын дүнгийн албан тодорхойлолтыг хавсаргана.

Монголын болон гадаадын их, дээд сургуульд суралцаж буй бол бүрэн дунд боловсролын үнэмлэх, дүнгийн хавсралтын нотариатаар баталгаажуулсан хуулбараас гадна тухайн суралцаж буй сургуулийн сүүлийн улирлын дүнгийн тодорхойлолтыг хавсаргана.

Бакалаврын зэргийн дипломтой бол бүрэн дунд боловсролын үнэмлэх, дүнгийн хавсралтаас гадна бакалаврын зэргийн диплом түүний хавсралтыг нотариатаар баталгаажуулан хавсаргана.

/дээр дурдсан боловсролын баримт бичгүүд англи эсвэл монгол хэл дээр биш бол хуулбарыг монгол хэл дээрх албан ёсны орчуулгын хамт хавсаргах/

8. Сонгон шалгаруулалтын бүртгэлийн хураамж 25 000 төгрөгийг төлсөн баримтын хуулбарыг хавсаргах;

Бүртгэлийн хураамжийг Төрийн сан дахь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дансанд бэлнээр болон бэлэн бусаар тушаана. Хураамж төлсөн баримтад бүртгүүлэгчийн овог, нэр, регистрийн дугаар, утасны дугаар, гүйлгээний утга буюу ямар тэтгэлэгт бүртгүүлэх тухай (СТС, бакалавр) мэдээллийг заавал оруулах шаардлагатай.

Дансны нэр: БСШУСЯам н.с

Дансны дугаар: 100900015431

Жич: Та цахим өргөдлийг бөглөж илгээсэн эсэхээс үл хамааран бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй тул сонгон шалгаруулалтад тавигдах шаардлагыг сайтар судалсны дараа төлбөрийг дансанд тушаана уу.

9. Цахимаар ярилцлагад орох буюу гадаадад суралцаж буй иргэн нэмэлтээр гадаад паспортын хуулбарыг хавсаргах;

Гадаад паспортын нүүр хуудас, хүчинтэй хугацааг харуулсан нүүр, тухайн оронд оршин сууж буй визтэй хуудас, нэвтрэн орсон тамга зэрэг мэдээлэл багтаасан нүүрийг нэг PDF файл болгон хавсаргана.

3. Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр магистрантур, докторантурт суралцахаар өргөдөл гаргагчийн баримт бичгийн шаардлага

Цахим өргөдөл бөглөж илгээх болон түүнд хавсаргах баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна.

Ерөнхий шаардлага:

- 1. Баримт бичиг тус бүрийг 1 PDF файл болгон тухайн баримт бичгийн монгол нэрээр нэрлэсэн байх;**
Жишээлбэл: Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, сургуулийн урилга, ерөнхий боловсролын сургуулийн гэрчилгээ, дүнгийн тодорхойлолт, ... гэх мэт
- 2. Нэг төрлийн баримт бичгийг 1 л удаа хавсаргаж оруулах;**
Хэрэв олон хуудастай баримт бичиг бол 1 PDF файл болгон урьдчилж бэлтгэсний дараа тухайн төрлийн баримт бичгийг системд нэг л удаа татаж оруулна. Нэг төрлийн баримт бичгийг дахин татаж оруулах үед системээс хавсаргах боломжгүй тухай анхааруулга өгнө.
- 3. PDF файл болгосон баримт бичгийн хуудасны хэмжээ A4 болон түүнээс доош хэмжээтэй байх;**
Хэрэв таны хавсаргасан PDF файлын доторх хуудас бүрийн хэмжээ A4-өөс дээш хэмжээтэй бол таны баримт бичгийг хэвлэж гаргах боломжгүй болохыг анхаарна уу. Тиймээс PDF файл болгосон баримт бичгийнхээ файлыг нээж, хуудас бүрийн хэмжээг шалгаж үзсэний дараа A4 болон түүнээс доош хэмжээтэй бол хавсаргаж болно.
- 4. Баримт бичгийн төрлийг зөв сонгох;**
Баримт бичгийг оруулахдаа баримт бичгийн төрлийг зөв сонгож, шаардсан баримт бичгийн бүх төрлийг бүрэн татаж оруулна. Хавсаргах ёстой баримт бичгийг системээс “Баримт бичгийн төрөл”-өөр нь шалгах бөгөөд төрөл дутуу тохиолдолд системээс өргөдөл илгээгдэхгүй тухай анхааруулга өгнө.
- 5. Хавсаргах 1 файлын дээд хэмжээ 5MB байх;**
- 6. PDF файл нь нууцлалтай (secured) файл биш байх;**
Хэрэв PDF файл нь нууцлалтай (secured) файл бол хавсаргах үед системээс хавсаргах боломжгүй тухай анхааруулга өгнө. Нууцлалгүй файлыг хавсаргах боломжтой байна.
- 7. Баримт бичгийн хуулбар цэвэрхэн, үг үсэг бүр уншигдахуйц байх;**
8. Сургуулийн урилга болон ерөнхий боловсролын гэрчилгээ бусад боловсролын баримт бичиг англи эсвэл монгол хэл дээр биш бол тэдгээрийн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг монгол хэл дээрх албан ёсны нотариатаар баталгаажуулсан орчуулгын хамт 1 PDF файл болгон хавсаргах;
9. Биечлэн ярилцлагад орох иргэн бүрдүүлсэн баримт бичгийн эх хувийг ярилцлагад орохдоо заавал авч ирэх;

Өргөдлийн шаардлага:

Дараах баримт бичгийн жагсаалтаас өөрийн өргөдөл гаргах тэтгэлэгт шаардлагатай баримт бичгийг хавсаргана.

Санамж: Доорх хэсэгт байж болох нийт баримт бичигт тавигдах шаардлагыг дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд тэтгэлэгт хүсэлт гаргагч нь зөвхөн зарлалд дурдсан шаардлагатай баримт бичгийг цахим өргөдөлд хавсаргахыг анхаарна уу.

1. Цахим өргөдөл бөглөж, илгээх;
Хэрэглэгчийн эрх үүсгэн системд нэвтэрч, цахим өргөдөл бөглөж илгээнэ. Ингэхдээ бүх мэдээллийг үнэн зөв бөглөж, дараах баримт, бичгүүдийг заасан шаардлагын дагуу өргөдөлд хавсаргана. Цахим өргөдлийн элсэлтийн мэдээлэл алхамд байгаа “Supporting statement” асуултуудыг англи хэл дээр өгөгдсөн тэмдэгтэд багтаан бичнэ.
2. Сургуулийн албан захидал/урилгын хуулбарыг хавсаргах;
Жагсаалтад багтсан сургуулиуд болон Болгар, Итали, Франц зэрэг улсын сонгодог урлагийн их сургуулийн магистрантур, докторантурын үндсэн, өдрийн ангийн сургалтад /хэлний бэлтгэл хамаарахгүй/ зарлагдсан мэргэжлийн чиглэлийн дагуу 2016 онд шууд суралцахаар элсүүлсэн тухай сургуулийн албан захидлын хуулбар, эсвэл суралцаж байгаа тухай албан захидлын хуулбарыг хавсаргана. Хэрэв та нэгээс дээш их сургуульд суралцах урилга авсан бол суралцахаар сонгож буй сургуулийн мэдээллийг цахим өргөдлийн элсэлтийн мэдээлэл хэсэгт оруулж энэ сургуулийн урилгыг баримт бичиг хэсэгт хавсаргана.
3. Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт хавсаргах;
Зөвхөн докторантурт суралцах өргөдөл гаргагчид эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт хавсаргана. Сурталчилгааны чанартай бүтээл хамаарахгүй.
4. Дараах хоёр төрлийн тодорхойлолтыг хавсаргах;
Зарлалд тавигдсан загварыг дагуу, дараах хоёр төрлийн тодорхойлолтыг англи хэл дээр ирүүлнэ.
 - Суралцах бэлтгэл, судалгаа, шинжилгээний ажлын туршлага, зан төлөвийн онцлогийг тодорхойлсон удирдагч, багш, эрдэмтний тодорхойлолт
 - Ажиллаж байгаа эсвэл ажиллаж байсан газрын ажил, зан байдлын тодорхойлолт
5. Бакалавр /магистрантурт өргөдөл гаргах бол/, бакалавр болон магистр /докторантурт өргөдөл гаргах бол/-ийн диплом, дүнгийн жагсаалтын нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргах;
Магистрт өргөдөл гаргах бол бакалаврын диплом болон дүнгийн жагсаалтын нотариатаар баталгаажуулсан хуулбар, докторт өргөдөл гаргах бол бакалавр болон магистрын диплом тэдгээрийн дүнгийн жагсаалтын нотариатаар баталгаажуулсан хуулбарыг тус тус хавсаргана.
6. Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргах;
Нийгмийн даатгалын дэвтрийн сүүлийн 5 жил хүртэлх мэдээллийг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. Үүнд: нийгмийн даатгалын дэвтрийн нүүр хуудас, сүүлийн 5 жил хүртэлх хугацааны төлөлт хийгдсэн тухай мэдээлэл, албан тушаалд томилсон, чөлөөлсөн тухай тэмдэглэлийг харуулсан хуудас зэргийг заавал оруулна.
7. Иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргах

Иргэний үнэмлэхний 2 талын нүүрийг оруулан нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргана.

8. Гадаад хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт өгсөн тухай баримтын хуулбарыг хавсаргах;

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад хэлний шалгалт /IELTS, TOEFL гэх мэт/ өгсөн гэрчилгээний хуулбар эсвэл суралцах сургуулийн гадаад хэлний шаардлагыг хангаж байгааг нотлох аливаа баримтын хуулбарыг хавсаргана.

9. Сонгон шалгаруулалтын бүртгэлийн хураамж 25 000 төгрөгийг төлсөн баримтын хуулбарыг хавсаргах;

Бүртгэлийн хураамжийг Төрийн сан дахь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 100900015431 тоот дансанд бэлнээр болон бэлэн бусаар тушаана. Хураамж төлсөн баримтад бүртгүүлэгчийн овог, нэр, регистрийн дугаар, утасны дугаар, гүйлгээний утга буюу ямар тэтгэлэгт бүртгүүлэх тухай (СТС, магистр эсвэл доктор) мэдээллийг заавал оруулах шаардлагатай.

Дансны нэр: БСШУСЯам н.с

Дансны дугаар: 100900015431

Жич: Та цахим өргөдлийг бөглөж илгээсэн эсэхээс үл хамааран бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй тул сонгон шалгаруулалтад тавигдах шаардлагыг сайтар судалсны дараа төлбөрийг дансанд тушаана уу.